



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/Н05


Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 113 дугаар  
сургуулийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 30,360,000 /гучин сая гурван зуун жаран мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 113 дугаар сургууль /Д.Намгар/-д зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 113 дугаар сургууль /Д.Намгар/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001163

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн №1 дугаар тушаалын хавсралт



Бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ		Эх үүсвэр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Компьютер	Comwin 1-15	15-6500 RAM 4096	2018 он	Сайн	ширхэг	15	2,024,000	30,360,000	БНСУ-ын Сөүл хотын Болговсролын газар, Нийслэлийн Болговсролын газрын хамтын ажиллагаа	Хандив